



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 20 өдөр

Дугаар А/225

Сүхбаатар сум

### Нэгж талбарыг нэгтгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3."г", Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 33 дугаар зүйлийн 33.1.1, Захиргааны ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 25 дугаар зүйлийн 25.1, 28 дугаар зүйлийн 28.1.3, 43 дугаар зүйлийн 43.1, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, аймгийн Засаг даргын 2011 оны "Аймгийн төвийн инженерийн шугам сүлжээ бүхий бүсийн хилийг шинэчлэн тогтоох тухай" А/39 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сүхбаатар сумын иргэн Чочос овогтой Ганбатын Ган-Эрдэнэ /ТЛ90122577/-ийн эзэмшиж байгаа газраа нэгтгэх хүсэлтийн дагуу эзэмшиж байгаа 3 нэгж талбарыг нэгтгэсэн Ганзам 7 дугаар багийн Сургуулийн 4 дүгээр гудамжны 412 тоотод байрлалтай 4308012181 нэгж талбарын дугаартай 286 м<sup>2</sup> газрыг анх олгосон хугацаагаар эзэмшүүлсүгэй.


2.Дээрх газарт кадастрын зураглал хийн, нэгж талбарын хувийн хэрэг үүсгэн, гэрчилгээ олгон эрхийг нь баталгаажуулж, газар эзэмшигчийн улсын бүртгэлд бүртгэж, холбогдох баримтуудыг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн дундын мэдээллийн санд оруулахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Б.Саруултөгс/-д даалгасугай.

3.Эзэмшилд олгогдсон газраа тохижуулж хамгаалах, газар эзэмших гэрээ байгуулан улсын бүртгэлд бүртгүүлэхийг иргэн Г.Ган-Эрдэнэд үүрэг болгосугай.

4.Эзэмшилд олгогдсон газрын ашиглалт, хамгаалалтын байдалд хяналт тавьж ажиглахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга /Ж.Отгонхүү/-д хариуцуулсугай.

5.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны 06 дугаар сарын 02- ны өдрийн А/263, 2018 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/250 дугаар захирамжийн иргэн Г.Ганбатад холбогдох хэсэг, 000693305 дугаартай гэрчилгээ, гэрээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ

C:\users\albanbichig2020\zahiramjA4.docx

4308012181





## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 25 өдөр

Дугаар А/226

Сүхбаатар сум

### Газар эзэмших эрхийг баталгаажуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3."г", Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 33 дугаар зүйлийн 33.1.1, Захиргааны ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 25 дугаар зүйлийн 25.1, 28 дугаар зүйлийн 28.1.3, 43 дугаар зүйлийн 43.1, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, аймгийн Засаг даргын 2011 оны "Аймгийн төвийн инженерийн шугам сүлжээ бүхий бүсийн хилийг шинэчлэн тогтоох тухай" А/39 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сүхбаатар сумын иргэн Чандмань свогт Цэндийн Бямбацогт /МЬ68033015/-ын Орхон 6 дугаар баг Д.Оюунболдын 1 дүгээр гудамжны 101 тоот хаягт байршилтай 4308003430 тоот нэгж талбарын дугаар бүхий 294м<sup>2</sup> худалдаа үйлчилгээний зориулалттай газрын эзэмших эрхийг баталгаажуулсугай.

2. Туузан метрээр хэмжилт хийгдэн анх олгогдсон дээрх газарт кадастрын зураглал хийн холбогдох баримтуудыг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн дундын мэдээллийн санд илгээж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож эрхийг нь баталгаажуулан, нэгж талбарын хувийн хэрэгт баяжилт хийж, газар эзэмшигчийн улсын бүртгэлд бүртгэхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Б.Саруултөгс/-д даалгасугай.


3. Эзэмшил газрынхаа арваас доошгүй хувьд ногсон байгууламж бүрдүүлэн, тохижуулж, хамгаалах, газар эзэмших гэрээ байгуулан улсын бүртгэлд бүртгүүлэхийг иргэн /Ц.Бямбацогт/-д үүрэг болгосугай.

4. Эзэмшилд олгогдсон газрын ашиглалт, хамгаалалтын байдалд хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга /Ж.Отгонхүү/-д хариуцуулсугай.

5. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Ц.Бямбацогтын эзэмшилд олгосон Сүхбаатар сумын Засаг даргын 1996 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 136 тоот шийдвэрийн холбогдох заалт, 032190 дугаартай газар эзэмших эрхийн гэрчилгээ, 04301-2003/03430 тоот гэрээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Ш.ОРГИЛ



C:\users\albanbichig2020\zahiramjA4.docx

4308003430